

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

### **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7,8 дахь хэсэг нэмсүгэй:

"7.1990 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан БНМАУ-ын Тэтгэврийн тухай хуульд төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан 4 ба түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн эхчүүд 20-иос доошгүй жил ажилласан бол нас харгалзахгүй тэтгэвэр тогтоохоор заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эхчүүдийн тэтгэврийн хэмжээг улсын дундаж тэтгэврийн хэмжээгээр тооцож олгоно.

8.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт хамаарахгүй боловч энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцлөөр 1997 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тэтгэвэр тогтоолгосон эхчүүдийн тэтгэврийн хэмжээг улсын дундаж тэтгэврийн хэмжээгээр тооцож олгоно."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,  
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,  
ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИУДЫГ  
ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд доор дурдсан агуулгатай 5<sup>2</sup> дугаар зүйл нэмсүгэй:

“5<sup>2</sup>. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэгт заасан эхчүүдийн тэтгэврийн хэмжээг улсын дундаж тэтгэврийн хэмжээгээр тооцож олгох журмыг Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ